

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Нэг: Ерөнхий зүйл

1.1 Сангийн сайдын 2018 оны 281 дугаар тугаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу ХХААХҮЯам болон харьяа байгуулага, төсөлүүдийн 2019 оны худалдан авах ажиллагааны тайланг боловсрууллаа.

“Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-75 дугаар тушаал, “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-338 дугаар тушаалаар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2019 онд худалдан авах арга хэмжээнд хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 7 худалдан авах ажиллагааг 6.2 тэрбум төгрөг, урсгал зардлын санхүүжилтээр 58 худалдан авах арга хэмжээг 18.8 тэрбум төгрөгөөр зохион байгуулж 87 хувийн биелэлттэй байна.

“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төсөл 2019 онд нийт 31 арга хэмжээний 5.1 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагаа хийхээр төлөвлөснөөс 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 4.6 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, бараа материал нийлүүлэх болон зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, нийтдээ 3.9 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Гэрээ байгуулсан арга хэмжээнүүдээс нийтдээ 407.8 сая төгрөгийг хэмнэсэн байна

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт төслийн хүрээнд нийт 38 нэр төрлийн худалдан авалтыг 5.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгт хийхээр төлөвлөснөөс 18 нэр төрлийн худалдан авалтыг амжилттай зохион байгуулж 3.1 тэрбум төгрөгөөр гэрээ байгуулсан нь 60%-ийн гүйцэтгэлтэй, 226.7 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.

Азийн хөгжлын банк (АХБ), Япон улсын засгийн газрын Ядуурлыг бууруулах Японы сан (ЯБЯС)-ын буцалтгүй тусламжийн санхүүжилтаар хэрэгжиж буй “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах” 9192-MON төсөл нь нийт 18 багц худалдан авах ажиллагааг төслийн хугацаанд хийхээр төслийн баримт бичигт тусгагдсан. Төслийн худалдан төлөвлөгөөний дагуу 2019 онд ажил гүйцэтгэх 2, бараа худалдан авах 7, зөвлөх үйлчилгээ сонгон шалгаруулах 4, нийт 13 худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллав. Үүнээс 2019 онд 8 худалдан авалтыг зарлаж, тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд амжилттай хийж хэрэгжүүлсэн бөгөөд шаардлагад нийцсэн хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулж 597,571.1 ам долларын өртөг бүхий 11 гэрээг байгуулсан.

Биокомбинат ТӨААТУУГазрын 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 9 тендер, тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар 21, шууд худалдан авахаар 31 нийт 61 төсөл арга хэмжээ хэрэгжүүлж 100% гүйцэтгэн ажилласан.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр нийт 26 худалдан авах арга хэмжээг 8.9 тэрбум төгрөгөөр 100% гэрээ байгуулан гүйцэтгэж ажилласан.

1.2 Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авах ажиллагааны талаарх тайлбар, үндэслэл болон хэрэгжилтийн мэдээллийг тусгана.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон түүний харьяа байгууллага, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, төрийн өмчит байгууллагуудын тайлант хугацаанд жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авах ажиллагаа хийгдээгүй болно.

1.3 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэгдээгүй болон дутуу биелсэн ажлын шалтгаан, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны хамт тусгана.

ХХААХҮЯ 1 худалдан авах ажиллагааг ХХААХҮСайдын тушаалаар хүчингүй болгож 8 зөвлөх үйлчилгээ нь оролцогч тендерт оролцох санал ирүүлээгүйн улмаас хэрэгжээгүй болно.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт төсөл нь “Бэлчээрийн удирдлага, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь” бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дунд оврын хадлангийн 6 иж бүрдэл, бага оврын хадлангийн 46 иж бүрдлийг 1.3 тэрбум төгрөгөөр худалдан авч төсөлд хамрагдсан малчдын бүлгүүд болон төслийн сумдад нийлүүлэхээр төлөвлөсөн ч төслийг санхүүжүүлэгч ОУБ-ХААХОУС-гийн дунд шатны хяналт үнэлгээний ажлын хэсгээс уг тоног төхөөрөмжийг үр дүнтэй ашиглах газар тариалан, ногоон тэжээл тариалах чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг хоршоод, чадавхижсан байгууллагуудад олгох нь зүйтэй гэсэн зөвлөмж өгч худалдан авалтыг цуцалсан. Худалдан авалтуудын техникийн үзүүлэлт, тендерийн баримт бичгийг Монгол, Англи хэл дээр бэлтгэж, ХААХОУС-гийн зөвшөөрөл авах системд оруулж хянуулсан боловч худалдан авалт цуцлагдсан болно.

ХААХОУС-гийн дээрх ажлын хэсгээс төслийн “Бизнесийн орчинг сайжруулах, нич бүтээгдэхүүн хөгжүүлэх” бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагаанд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан сүү, бяслаг, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо, чацаргана, ноосон брэнд бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа, мөн сүү, бяслаг, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо, чацаргана, ноосон бүтээгдэхүүний нэмүү өртгийн судалгаа, шинжилгээ хийх байгууллагуудыг сонгон шалгаруулах 12 зөвлөх үйлчилгээ/412.5 сая төгрөг төсөвт өртөгтэй/-ний тендерийг 2 үе шатанд нь цуцалсан.

Дээрх бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд жимс, жимсгэнэ, байцаа ба хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах болон сав баглаа боодлын 6 нэр төрлийн бага оврын тоног төхөөрөмжийг 177.0 сая төгрөгийн төсөвт өртөгт худалдан авч төсөлд хамрагдсан жижиг, дунд бизнес эрхлэгчдэд нийлүүлэхээр төлөвлөсөн хэдий ч ХААХОУС-гийн дунд шатны хяналт үнэлгээний ажлын хэсгээс цуцалсан. Мөн уг бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Сүхбаатар аймгийн Баруун Урт сум, Өвөрхангай аймгийн Хархорин суманд тус бүр нэг борлуултын цэгийг нийт 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгт барихаар төлөвлөсөн ч орон нутгийн зүгээс газрын асуудлыг шийдээгүй хугацаа алдсан тул 2020 онд хийхээр төлөвлөж байна. Борлуулалтын цэг барих ажлын зураг, төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.

“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслийн үйл ажиллагааны хүрээнд 2019 онд тендер шалгаруулж, худалдан авалтын гэрээ байгуулах ажил 90.0%, гэрээний дагуу санхүүжүүлэх ажил нь 85.4%-тай байна.

2019 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар төлөвлөгөөнд тусгагдсан 31 худалдан авах ажиллагаанаас нийт 27 арга хэмжээний гэрээ байгуулагдан хэрэгжиж байгаагаас 19 арга хэмжээний худалдан авах ажиллагаа бүрэн дуусч, зөвлөх үйлчилгээний 6, бараа материал нийлүүлэх 2 арга хэмжээний гэрээ хэрэгжиж байна. Тодорхой шалтгааны улмаас худалдан авалт эхлээгүй 2020 он руу шилжихээр байгаа 4 арга хэмжээ байна.

Сонгогдсон хоршоонд ноосны агуулах барих болон худаг гаргах ажлууд аймгийн холбогдох газруудаас газрын талаар тодорхой шийдвэр гарахгүй удааширч, мөн зураг төслийн ажлууд хийгдээгүй байгаа тул 2 ажлын тендер шалгаруулалтын асуудал тодорхойгүй байна. Зөвлөх үйлчилгээний 2 арга хэмжээг ХХААХҮЯ-наас өөрчлөхөөр ажиллаж байгаа.

1.4 Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийсэн эсэх тухай бичнэ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан худалдан авах арга хэмжээнүүд нь тендерийн хүчинтэй байх хугацаанд хэрэгжсэн болно.

1.5 Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчил, түүнийг хэрхэн засаж залруулсан тухай бараа, ажил, үйлчилгээ тус бүрээр тодорхойлон бичнэ.

Худалдан авах ажиллагааны явцад гарсан ямар нэгэн зөрчил байхгүй.

1.6 Худалдан авах ажиллагааны талаар гарсан гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдлын тухай тусгана.

“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслийн 2019 онд худалдан авах ажиллагааны явцад “Бэлчээрийн монгол малын сүүний хими, биохимийн найрлагыг тогтоох, түүгээр зохицуулах үйлчилгээтэй хүнс үйлдвэрлэх туршилт, судалгаа”-ны тендер шалгаруулалтын үеэр нэг тендер оролцогч гомдол гаргасан. Гомдлын дагуу захиалагчийн зүгээс дэлгэрэнгүй хариу өгч, Сангийн яам уг гомдлыг хянан үзэж тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэх шийдвэр гаргаж, гомдол гаргагч шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн.

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төслийн санхүүжилтээр G-01 дугаартай трактор, тоног төхөөрөмж худалдан авах тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй Бадрангуй орших ХХКомпани гомдол гаргасан бөгөөд АХБанк болон СЯамнаас захиалагчийн шийдвэрийг зөв гэсэн шийдвэрийг гаргасан.

Биокомбинат УТҮГ-ын зарласан БИОК/20190236 тоот “Үйлдвэрийн хэрэгцээний нүүрс худалдан авах” тендер оролцсон “Бест вүүдэн хаус”ХХК –ны гаргасан гомдлыг “Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газрын 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/1039 тоот бичгийн дагуу ТӨӨЗ 18-н 2а-д заасан 2017, 2018 оны борлуулалтын дундаж орлогыг 300 сая төгрөг байсныг 50% болтол бууруулж нээлттэй тендер шалгаруулалт ажиллагааг үргэлжлүүлэн явуулсан. Худалдан авах ажилгааны маркетингийу албанаас зохион байгуулсан бусад тендерээс гомдол ирээгүй ба хуулийн хугацааг мөрдөж зохион байгуулан ажиллаа.

1.7 Чанар стандартын шаардлага хангасан дотоодын бараа худалдан авсан мөнгөн дүн, нийлүүлэгчийн нэр, гэрээний хэрэгжилтийн талаар тусгах.

ХХААХҮЯам нь дотоодын үйлдвэрийн Биокомбинат ТӨААТҮГазраам малын эм, вакциныг 3.4 тэрбум төгрөгөөр, Шим ХХКомпаниас бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготны хор 1.0 тэрбум төгрөгөөр худалдан авалт хийж ажилласан.

“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслийн хөрөнгөөр 2019 онд бараа материал, тоног төхөөрөмжийн 3 тендерийн 303,538.0 мян.төгрөгийн өртөгтэй дотоодод үйлдвэрлэгдсэн бараа худалдан авахаар гэрээ байгуулсан болно

Биокомбинат ТӨААТҮГазар 2019 оны нийт худалдан авалтыг 30%-иас доошгүйг дотоодоос худалдан авч үндэсний үйлдвэрлэлээ дэмжин ажилласан байна.

Хоёр. Худалдан авах ажиллагааны цахим системийг ашигласан талаар

2.1 Худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан тендер шалгаруулалтын тоо, хувь болон системийн талаар дүгнэж ирүүлнэ.

ХХААХҮЯам нь нийт 65 худалдан авах ажиллагааны 35 худалдан авах арга хэмжээг цахим системээр зарлан зохион байгуулж, 24 худалдан авах арга хэмжээг

хуулийн хүрээнд шууд гэрээ байгуулах болон шууд худалдан авах журмын дагуу зохион байгуулан ажилласан.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт төсөл нь худалдан авах ажиллагааны цахим системээр 14 тендер шалгаруулалтыг зохион байгуулсан.

“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслийн зээлийн хэлэлцээр болон Төслийн удирдлагын гарын авлагын дагуу тендер шалгаруулалтыг уламжлалт аргаар явуулсан болно. Харин тендерийн зар, урилга, үр дүнгийн талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем дээр байршуулж, холбогдох нэмэлт мэдээллийг давхар оруулж ажилласан.

Биокомбинат ТӨААТУУГ нь Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баталсан бөгөөд хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт захиалагч тендер шалгаруулалт бүрийн урилга, үр дүнг цахим сүлжээнд зарлаж байхаар хуульчилсанын дагуу 2019 оны худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр бүх тендерээ зарлаж, хүлээн авч, тендерийн үр дүнг тухай бүр цахим хэлбэрээр байршуулан ажилласан.

2.2 Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу цахим дэлгүүрийн ашиглалт болон тухайн жилд худалдан авсан бараа, үйлчилгээний тоо, мөнгөн дүн, гэрээний хэрэгжилтийн талаар ирүүлнэ.

Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу 11 худалдан авах арга хэмжээг 70.7 сая төгрөгөөр зохион байгуулж ажилласан.

2.3 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага) ерөнхий гэрээний зохион байгуулсан тендер, шалгарсан аж ахуй нэгжийн тоо, шалгараагүй оролцогчийн үндэслэл болон холбогдох мэдээлэл, худалдан авалт хийсэн бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хэрэгжилтийн талаар тусгах

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 388 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар худалдан авах арга хэмжээ зохион байгуулагдаагүй болон орон нутагт ХХААХҮСайдын 2019 оны А-106, А-152, А-185 дугаар тушаалуудаар 31 худалдан авах арга хэмжээний эрхийг шилжүүлэн ажилласан.

Гурав. Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны талаар

3.1 Тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын тоо, тэдгээрийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаар ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааг зааварчилгаа, аргачлалаар хангасан байдал болон түүнд хяналт тавьж ажилласан талаар тусгана.

ХХААХҮС-ын харьяа байгууллагуудад худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаар ерөнхий мэдээлэл, зааварчилгаа, аргачлалаар хангаж ажилласан.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ өгсөн тухай зөвлөмж, дүгнэлт болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг хавсарган ирүүлнэ.

ХХААХҮЯ нь 2019 оны худалдан авах ажиллагааг 100 хувь цахим системээр зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.

Дөрөв. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаарх дүгнэлт, санал

4.1 Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үр дүнгийн талаарх өөрийн үнэлгээ, дүгнэлтийг гаргаж тавина.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл 2019 онд нийт 31 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бараа материал, тоног төхөөрөмж худалдан авах 19 худалдан авах ажиллагаа бүрэн дуусч, зөвлөх үйлчилгээний 6, тоног төхөөрөмж бараа материал нийлүүлэх 2 ажил хуваарийн дагуу үргэлжилж 2020 онд хэрэгжиж дуусна. 2019 онд зарлагдаагүй ажлын 2, зөвлөх үйлчилгээний 2 тендер шалгаруулалтын асуудлыг ХХААХҮЯ шийдвэрлэхээр байгаа.

4.2 Гэрээний хэрэгжилтэд хэрхэн хяналт тавьж ажилласан талаарх мэдээллийг тусгана.

ХХААХҮЯ нь гэрээ байгуулах эрх олгох тушаалаар хяналт тавьж ажиллахыг холбогдох газруудад үүрэг болгон өгч ажилласан.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл нэмэлт санхүүжилт төсөлийн зохицуулагч нь ХХААХҮЯ-ны Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар томилогдож, худалдан авах ажиллагааг зохих хууль, журмын дагуу явуулахад хяналт тавин ажиллаж байна. Хэрэгжиж буй гэрээний хэрэгжилтэд ХХААХҮЯ, мэргэжлийн холбоод болон төслийн баг хяналт тавьж ажиллаж байна. Төслийн худалдан авах ажиллагааны явцын талаарх тайланг долоо хоног бүр СЯамны Хөгжлийн санхүүжилтийн газарт хүргүүлж байгаа.

4.3 Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг цаашид улам үр дүнтэй болгох санал, зөвлөмж, хүсэлтийг тусгаж өгнө.

Худалдан авах ажиллагааг цахим системээр зарлан тендерийг худалдан борлуулсан үнэ нь тухайн тендертэй холбогдох зардлыг нөхөхгүй байгааг анхаарч үзэх.